Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,306.1 мянган төгрөгөөр буюу 29.4 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Урьдчилж гарсан зардал | 20,000.0 | | (20,000.0) |
| Бараа материал | 27,188.1 | 25,875.6 | (1,312.5) |
| Үндсэн хөрөнгө | 89,781.0 | 70,787.4 | (18,993.6) |
| **Нийт хөрөнгө** | **136,969.1** | **96,663.0** | **(40,306.1)** |
| Өр төлбөр | 1,688.7 | | (1,688.7) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 135,280.4 | 96,663.0 | (38,617.4) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **136,969.1** | **96,663.0** | **(40,306.1)** |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Урьдчилж гарсан 20,000.0 мянган төгрөгийн зардал нь тайлант онд хэрэгжсэнээр үлдэгдэлгүй тайлагнагдсан,
- Үндсэн хөрөнгийн данс 18,993.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 10,158.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн ИТХ-ын 2023 оны 123 дугаар тогтоолоор 75,553.6 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас,
- Засгийн газрын оролцоо данс нь 38,617.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,272,763.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 1,202,844.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,069,919.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил болон НДШ-ийн зардлыг 51,992.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,000.0 мянган төгрөгөөр,
- Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн зардлыг 50,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол,
- Хангамж, бараа материалын зардлыг 21,521.0 мянган төгрөгөөр,

- Эд хогшил, урсгал засварын зардлыг 25,660.0 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр,
- Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 31,180.0 мянган төгрөгөөр,
- Хоол, хүнсний зардлыг 31,320.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл сурталчилгааны зардал 22,618.0 мянган төгрөгөөр,
- Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлыг 214,652.0 мянган төгрөгөөр,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 357,725.0 мянган төгрөгөөр,
- Ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээний зардлыг 561,160.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 54,803.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгол хийсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил болон НДШ-ийн зардлыг 54,953.5 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 49,000.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл, сурталчилгааны зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол,
- Хангамж, бараа материалын зардлыг 7,150.4 мянган төгрөгөөр,
- Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн зардлыг 47,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,124,723.0 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,124,723.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна. Санхүүжилтийг тодруулбал:

- *Үндсэн үйл ажиллагааны зардалд 517,498.0 мянган төгрөг,*
- *Мэдээлэл, сурталчилгааны зардалд 15,000.0 мянган төгрөг,*
- *Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардалд 93,400.0 мянган төгрөг,*
- *ИТХ-д суудалтай намуудад олгох санхүүжилтийн 185,000.0 мянган төгрөг,*
- *Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардалд 7,000.0 мянган төгрөг*
- *Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн зардалд 3,000.0 мянган төгрөг,*
- *Хуралдааны зардалд 83,825.0 мянган төгрөг,*
- *ГХУСАХЗ-д 220,000.0 мянган төгрөг гэх мэт.*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 956,950.4 мянган төгрөг буюу 85.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 74,161.2 мянган төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлын төсвийг 61,915.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 517,498.0 | 443,336.8 | 74,161.2 | 85.7 |
| 2 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 15,000.0 | 11,398.0 | 3,602.0 | 76.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 93,400.0 | 31,484.2 | 61,915.8 | 33.7 |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урам | 7,000.0 | 4,084.3 | 2,915.6 | 58.3 |
| 5 | ИТХ-д суудалтай намуудад олгох санхүүжилт | 185,000.0 | 185,000.0 | 0.0 | 100.0 |
| 6 | Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр | 3,000.0 | 3,000.0 | 0.0 | 100.0 |
| 7 | Ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээ | 83,825.0 | 61,244.7 | 22,580.3 | 73.1 |
| 8 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 220,000.0 | 217,402.3 | 2,597.7 | 98.8 |
| | **Дүн** | **1,124,723.0** | **956,950.4** | **162,772.6** | **85.1** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130050001 тоот дансанд Цагаатгалын улсын комиссоос 480,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 25,200.0 мянган төгрөг, Хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийллийн төвөөс 13,200.0 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,642.0 мянган төгрөг зэрэг нийт 510,842.0 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн ИТХ нь 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 25,650.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Шатахуун худалдан авах" тендерийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, Ник ХХК нь 25,650.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлж, шаардлага хангаснаар гэрээ байгуулан ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ХХОАТ болон НДШ-ийн тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,701,662.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **17,016.6** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор аймгийн ИТХ нь бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн, зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгоогүй, автомашиныг дотор албан хэрэгцээнд ашиглаагүй, зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дараах зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

- Бичиг хэргийн зардлыг 3,266.5 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 3,921.6 мянган төгрөгөөр,
- Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс худалдан авах зардлыг 13,288.3 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн зардлыг 5,309.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн бол “Нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ой”-н арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаанд тодорхой хэмжээний зардал гаргасныг зөрчлөөр тооцож, албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын мэдээлбэл зохих 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар "Санхүүгийн тайланд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд эхний үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлснийг аудитын явцад залрууллаа.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 129,693.3 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, шилэн данс болон үндсэн хөрөнгө, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 4 зөвлөмж өгснөөс 45.5 хувийг нь хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 7 | 129,693.3 | 3 | 61,739.2 | 42.9 |
| Зөвлөмж | 4 | | 2 | | 50.0 |
| **Нийт дүн** | **11** | **129,693.3** | **5** | **61,739.2** | **45.5** |

### Дараагийн аудитаар анхаарах асуудал

Олон нийтийн цагдаагаар ажиллах иргэдийг холбогдох журмын дагуу сонгож буй эсэх, ГХУСАХЗ-аас олгож буй урамшууллыг дараагийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **10,078.4** мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулаа. Үүнд:

- 2023 онд худалдан авсан үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тогтоогоогүй, 3 дугаар улирлын үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй зэргээс санхүүгийн үр дүнг 6,256.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон 3,642.0 мянган төгрөгийн санхүүжилтийн дансны ангиллыг буруу бүртгэсэн,
- Бичиг хэргийн зардлын 180.0 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд бүртгэсэн.

Аудитаар нийт 53,713.8 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч 1,015.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22,091.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 30,606.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт:

**5.1.1** Тус газрын архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Н.Оюун-Эрдэнэд нярвын албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдлийг тухайн албан тушаалын цалингаас бус бичиг хэргийн албан тушаалын цалингаас тооцож нийт **415.4** мянган төгрөг илүү тооцож, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.1.2** Ник шатахуун түгээх газартай байгуулсан гэрээний дагуу тайлант хугацаанд худалдан авсан шатахууны үнийн дүнгийн 3 хувьтай тэнцэх **600.0** мянган төгрөгийн урамшуулал олгосныг бүртгэл тайланд тусгаагүй бөгөөд зарцуулалт нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,* 14 дүгээр зүйлийн 14.4.1-д “*Аж ахуйн бүх ажил, гүйлгээ;” 14.4.5: “Бүх орлого;”, 14.4.6: “бүх зардал”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Шийдвэрлэсэн нь:* Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага:**

**5.2.1.** Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс дараах **22,091.6** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 325.9 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 136.0 мянган төгрөгийн, цалингийн 74.0 мянган төгрөгийн зэрэг нийт **535.9** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн боловч бүртгэл тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.
- Батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **9,717.7** мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:
    - ➢ *Албан томилолтын зардлаас Улаанбаатар хотод шатрын тэмцээнд оролцсон 3 иргэнд 426.0 мянган төгрөг,*
    - ➢ *Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас Монгол-Солонгос багш нарын хамтарсан сургалтад 4,550.0 мянган төгрөг,*
    - ➢ *Дотоодын зочин төлөөлөгч хүлээн авахад ИТХ-ын хуралдааны зардлаас 3,187.0 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн зардлаас 1,554.7 мянган төгрөг зэрэг нийт 4,741.7 мянган төгрөг,*
- Ажил гүйцэтгэх гэрээ, тайлан, хүлээн авсан акт зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ГХУСАХЗ-аас Сэлэнгэ шүтээн ХХК-д **780.0** мянган төгрөгийг шилжүүлж, бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.7 дахь *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
- Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг алдагдуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн нийт **11,058.0** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх " *Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, 15.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:
    - ➢ *Аймгийн ИТХ-ын танилцуулгыг хэвлүүлэхэд 300 ширхэг 1,908.0 мянган төгрөг,*

> ➢ *Цаасан тор хийлгэхэд 2,550.0 мянган төгрөг,*
> ➢ *Нутгийн удирдлагын байгууллагад сонгогдож, томилогдож байсан ахмад, дунд, залуу үеийн төлөөлөгчдийн туршлага солилцох уулзалт арга хэмжээ зохион байгуулж, "Хонгор морьт" амралтад хүлээн авахад 6,600.0 мянган төгрөг зэрэг.*

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх *"...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"* гэсэн заалтын дагуу аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Э.Оюунболд, нягтлан бодогч Б.Болормаа нарт сахилгын шийтгэл ногдуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.4.** Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Хурлын төлөөлөгчдийн хоол, зочид буудлын зардлыг хурлын ирцийг үндэслэн гүйцэтгэлээр бус нийт гишүүдийн тоогоор Шинэбадрах, Номадсрэзидэнс, Гэбиргэ зэрэг компаниудад шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг эдийн засгийн ангилал, зардлын бүлгээр бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, байгаа нь төсвийг зардлын бүлгээр хянах зарчмыг алдагдуулж байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх " *Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд болон* Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*", 4.2.1.10: "*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

**Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаатай холбоотой томилолт, шатахуун, хичээл сургалт зэрэг урсгал зардлыг хуралдааны зардалд тусган батлаагүйгээс ИТХ-ын ажлын албаны буюу үндсэн үйл ажиллагааны зардлаас төлөөлөгчдийн буюу хуралдааны зардалд хөтөлбөр хооронд гүйлгэн 4,820.0 мянган

төгрөгийн шатахуун, 7,396.4 мянган төгрөгийн томилолт, 5,796.0 мянган төгрөгийн хичээл сургалтын зардал зэрэг нийт **18,012.4 мянган** төгрөгийн зориулалт бус зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална"*, 5.1.2 дахь *"Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх"* гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан " Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Зардлыг эдийн засгийн ангилал, хөтөлбөрөөр үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

***НДШ болон ХХОАТ-ын тайлагналтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Нийгмийн даатгалын тайланд албан хаагчдын цалинг дутуу тайлагнасан, татварын тайланд албан хаагчдын цалинг илүү болон хувь хүнээс суутгасан албан татварыг буруу тайлагнаснаас дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тайланд 3 албан хаагчийн 3,311.5 мянган төгрөгийн цалинг дутуу болон ХХОАТ-ын тайланд 1 албан хаагчийн 3,214.0 мянган төгрөгийн цалинг илүү,
- Хувь хүнд олгосон орлогоос суутгасан 2,712.3 мянган төгрөгийн, цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан 3,356.6 мянган төгрөгийн албан татварын илүү төлөлттэй гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.2-т *"Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* 2024 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох тайланг залруулж, үнэн зөв тайлагнах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5[3] дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[3] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тодорхойлоогүй, 3 дугаар улирлын элэгдлийг байгуулаагүй. | 1 | 6,256.4 | 1 | 6,256.4 | | | 1 | 6,256.4 | | | | |
| Нэмэлт санхүүжилтийн орлогын дансны ангилал буруу бүртгэсэн. | 1 | 3,642.0 | | | 1 | 3,642.0 | 1 | 3,642.0 | | | | |
| Зардлын ангилал буруу бүртгэсэн. | 1 | 180.0 | | | 1 | 180.0 | 1 | 180.0 | | | | |
| **Дүн** | **3** | **10,078.4** | **1** | **6,256.4** | **2** | **3,822.0** | **3** | **10,078.4** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин илүү олгосон | 1 | 415.4 | 1 | 415.4 | | | | | | | | |
| Анхан шатны баримтгүйгээр шатахуун зарцуулсан | 1 | 600.0 | 1 | 600.0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өр төлбөр үүсгэсэн боловч бүртгэл, тайланд тусгаагүй | 3 | 535.9 | | | 3 | 535.9 | | | | | | |
| Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй | 3 | 9,717.7 | | | 3 | 9,717.7 | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн | 1 | 780.0 | | | 1 | 780.0 | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн | 3 | 11,058.0 | | | 3 | 11,058.0 | | | | | | |
| Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй | 1 | | | | | | | | 1 | 2 | | |
| Төсвийн төлөвлөгөөг үнэн зөв төлөвлөөгүй | 1 | 18,012.4 | | | | | 1 | 18,012.4 | | | | |
| Албан хаагчийн цалинг НД болон татварын тайланд илүү, дутуу тайлагнасан | 1 | 6,525.5 | | | | | 1 | 6,525.5 | | | | |
| Татварын тайланд суутгасан татварыг дутуу тайлагнасан | 1 | 6,068.9 | | | | | 1 | 6,068.9 | | | | |
| **Дүн** | **16** | **53,713.8** | **2** | **1,015.4** | **10** | **22,091.6** | **3** | **30,606.8** | **1** | **2** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |